



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-13

<i>1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслүүд /Засгийн газар 2026.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	4-13
---	------

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 06 дугаар сарын 14-ний
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 8 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Анандбазар.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслүүд /Засгийн газар 2026.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн

хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсвийн төслийн талаар Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж үг хэлэв.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 39 минут үргэлжилж, 8 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 87.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Б.ПҮРЭВДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 14-ний
өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим
12 цаг 20 минут.

ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцээж ирлээ. Дэд хорооны ирц 75 хувьтай байна. Ирцийг танилцуулъя.

16 дугаар тойрог Пүрэвдорж, 4 дүгээр тойрог Анандбазар тасалсан, 29 дүгээр тойрог Амартүвшин ирсэн байна, 14 дүгээр тойрог Батжаргал ирсэн байна, 12 дугаар тойрог Батсуурь ирсэн байна, 23 дугаар тойрог Булгантуяа ирсэн байна, 20 дугаар тойрог Ганбаатар ирсэн байна, 1 дүгээр тойрог Тэмүүлэн ирсэн байна.

Ирц 87.5 хувьтай болж Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 1 дүгээрт Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 2023 оны 6 сарын 08-ны

өдөр мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, санал дүгнэлт байнгын хороонд хүргүүлнэ ээ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Эрхэм дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өсөж гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3.8 тэрбум ам.долларт хүрч сай сайжраад байна. Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлагыг бий болгож байна. Дээр дурдсан эдийн засаг нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэдийнх орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотгол төсөлд тусгалаа.

Тухайлбал

1. Хүүхдийн мөнгөн тэтгэмж хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох, 2 тэтгэврийн зөрүүний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж авто замын сүлжээг өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.7 их наяд төгрөгөөр нэгдсэн төсвийн нийт зарлага 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1.6 их наяд төгрөг буюу анх батлагдсан ДНБ-ий 2.6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөвөө.

Байнгын хорооны дарга, дэд хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 онд төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхланд баярлалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий

аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна.

Ажлын хэсэг. Ажлын хэсгийн 6 номер микрофон өгөөрэй.

Д.Занданбат: Улсын Их Хурлын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781,9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371.4 тэрбум төгрөг буюу 37.2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.6 хувь байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагыг 1 их наяд 896.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөснөөс урсгал зардлыг 1 их наяд 666.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 256.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж эргэж төлөгдөх цэвэр зээлийг 27 тэрбум төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.

Хуулийн төслийг боловсруулахдаа төсвийн орлогыг нийгмийн сайн сайхны төлөө тэгш хүртээмжтэй хуваарилах бодлогыг баримталж төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж дараах байдлаар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Үүнд:

Урсгал зардлын өсөлтийн 59.4 хувь буюу 990.1 тэрбум төгрөг нь төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх 23.7 хувь буюу 394.5 тэрбум төгрөг нь өндөр настны тэтгэврийн зөрөөг арилгах. Тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэх 10 хувь буюу 167.2 тэрбум төгрөг нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нөхөн болон хүсэлт гаргасан бүх хүүхдэд олгох 5.4 хувь буюу 89.8 тэрбум төгрөг нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хувь хэмжээг өсгөхөд 1.5 хувь буюу 25 тэрбум төгрөгийг бусад үйл ажиллагаанд зарцуулахаар тооцсон байна. Хөрөнгийн зардлын төсвийг 256.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тооцно.

Нийслэл хотод түгжрэлийг бууруулах холбоос зам төслийн санхүүжилтэд 187 тэрбум төгрөг, 22 аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох хөрөнгө оруулалтын арга хэмжээний төсвийг 69.5 тэрбум төгрөгөөр нэмж төлөвлөсөнтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын төсөв өсөхөд СЕХ-ны хөрөнгө оруулалтын зардлын төсөвт сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмж техник хэрэгслийн зардалд 16 тэрбум төгрөг, ХЗДХ-ийн сайдын хөрөнгө оруулалтын зардлын төсөвт УБЕГ-т сонгуулийн бүртгэлийн техник хэрэгслийн зардалд 18.5 тэрбум төгрөгийг тусган төлөвлөсөн нь нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсвийн зардал нь нийт 405.5 тэрбум төгрөгөөр өсөхөд өндөр настны тэтгэврийн зөрүүг арилгах тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулж 10 хувиар нэмэгдүүлэхэд 389.8 тэрбум төгрөг, төрийн албан хаагчдын цалингийн шинэчлэлт нь 10.1 тэрбум бусад үйл ажиллагаанд 5.6 тэрбум төлөвлөсөн нь нөлөөлсөн байна.

ЭМД-ын сангийн 2023 онд батлагдсан төсвийн зарлага 1 их наяд 603,5 тэрбум болж 1 их наяд 481.4 тэрбум төгрөгөө нэмж тооцсон нь сангаас олгох зарим тусламж үйлчилгээний санхүүжилтийн тарифыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой байна. Зардлын эх үүсвэрийг ЭМД-ын санд төлөх төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой 97 тэрбум төгрөг эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалин нэмэгдүүлэх арга хэмжээнд олгох улсын төсвийн урсгал шилжүүлэхээс 25.1 тэрбум төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс болон нийгмийн халамжийг нэмэгдүүлэхэд нийт зарлагыг төлөвсөн нь иргэдийн амьжиргааг дэмжих эерэг талтай хэдий ч өсөн нэмэгдэж буй энэ зарлага нь цаашид байнга гарах тул орлого нь тасралтгүй байх зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр бүрдүүлэхэд эрсдэл үүсэж болзошгүйг анхаарч үзэх шаардлагатай юм. Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хянан шалгахын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат даргад баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Болдын Жавхлан Сангийн сайд, Хүрэлбаатарын Булгантуяа Булгантуяа хаана байгаа юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Доржсүрэнгийн Занданбат Монгол Улсын Ерөнхий аудитор, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч,

тэргүүлэх аудитор, Ядамын Самбууням Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга. Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө оруулалт хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Байгальмаагийн Одонтуяа Сангийн яамны өрнийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Нарантуяагийн Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга.

Ер нь нэлээн олон албан тушаалтнууд ирээгүй байна шүү. Тэгэхээр энэ цалин нэмэх, тэтгэвэр нэмэх, хүүхдийн мөнгийг 100 хувь болгох ийм одоо гол зохицуулалтыг хийж байгаа. Төсвийн тодотгол дээр одоохондоо яришг уу? Дараагийн удаа 2025, 2024 оны төсвийн хууль хэлэлцэхэд тэгээд бүгдийг нь заавал байлгана шүү.

Тэгээд байлгахгүй бол хурал хойшлох шалтгаан болно.

Хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүн байна уу? Би дэгийг танилцуулъя.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд асуулт хариултыг мэтгэлцээний зарчмаар буюу харилцан мэтгэлцэх зарчмаар явуулж болно гэсэн ийм заалт байдаг. Энэний дагуу Ерөнхий сайдын сонсголыг бид бүхэн хийж байгаа. Тэгэхээр би энэ дээр асуултыг асуугаад явна. Ерөнхийдөө мэдээж энэ тодотгол ард иргэдэд хэрэгтэй бас нөгөө талаараа бас эдийн засагт томоохон эрсдэл авчрахуйц ийм ийм одоо тодотгол болж байгаа учраас иргэдэд мэдээллийг бүрэн хүргэх үүднээс асуултыг асуугаад манай албан тушаалтнууд ялангуяа одоо Сангийн сайд хариулаад явах байх гэж бодож байна.

Энэ улсын төсвийн тодотгол хийх үндэслэл дээр тодорхой үндэслэлүүд байгаа. Тэгэхээр энэний гол үндэслэл болох төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд төсвийн зохицуулалт хийх замаар одоо энэ орлогыг зарцуулж байгаа гэж ийм заалт орж ирсэн байгаа. Тэгэхээр энэ миний ойлгож байгаагаар бол Монгол Улсын эдийн засгийн ялангуяа одоо экспортын уул уурхайн экспортын нэмэгдсэнээр тодорхой орлого нэмэгдэж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр орлого нэмэгдэхээр тодотгол хийнэ гэж л ойлгосон. Гэтэл одоо энэ дээр тийм үндэслэл дотроо энэ заалт байхгүй байгаад байна. Тэгэхээр энэ улсын төсвийн орлого яг ямар ямар нөхцөл байдлаар оны эхнээс нэмэгдсэн юм бэ? Тэр нь ямар үндэслэл болж байгаа юм бэ гэдгийг бас тайлбарлаж өгнө үү?

Жавхлан сайдын микрофоныг өгье.

Түр хүлээж байгаарай. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Та сая гол үндэслэлээ зөв хэллээ. 34.1.4-өөр буюу төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд зохицуулалт хийх зайлиггүй шаардлага гарч ирсэн учраас төсвийн тодотгол хийх эрх нээгдэж байгаа гэсэн үг. Тэр нь юу вэ гэхээр Хууль зүйн үндэсний хүрээлэн Хууль зүй, дотоод хэргийн яаман дээрээс Улсын Их Хурал руу одоо хуулийн дагуу шилжиж байгаа Улсын Их Хурлын тогтоол гарч Засгийн газарт үүрэг өгсөн байгаа. Тийм учраас одоо энэ 2 ерөнхийлөн захирагчийн хооронд Засгийн газрын одоо тодорхой нэгж шилжээд Их Хурал руу шилжээд төсөв мөнгө одоо дагаж тийшээ шилжих шаардлага үүсэж байгаа. Энэ бол гол үндэслэл. Энийг одоо дагаж тодотгол хийх эрх нээгдэж байгаа гэсэн үг.

Тийм учраас энэ удаагийн хийгдэж байгаа бүх одоо тодотгол маань одоо энийг дагаж хийгдэж байгаа гэж ойлгож болно.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ бол нэг жижигхэн юу л байгаа юм шалтгаан л гэж ойлгож байна. Тэгэхээр энэ чинь тэр 2 байгууллагад шилжсэний төлөө 1.8 их наядын зардал шийдэгдэхгүй шүү дээ. Тэгэхээр төсөв яагаад тэлсэн бэ гэх дээр нүүрсний орлого оны эхнээс өнөөдрийг хүртэл 54 хувиар өссөн байгаа.

Дээрээс нь татварын орлого 36 хувиар өссөн байж байгаа. Тэгэхээр энэ 2-ын нийлбэр нийтд 344 тэрбум төгрөг байна. Тэгэхээр энэ 1.8 гэдгийг тавьж байна гэдэг нь өөрөөр хэлбэл оны эхнээс 340 тэрбум төгрөгөөр нэмэгдчихээр оны эцэс хүртэл 1,8 их наяд нэмэгдэнэ гэж тооцоод ингэж цалингаа нэмнэ нэмнэ гэдэг бол бас тодорхой эрсдэлд оруулж байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр ер нь нүүрсний орлого бол цаашидаа нэмэгдэхгүй байх тийм нөхцөл байдал бий болж байна.

Ялангуяа одоо Хятадын Чин хан доу боомт дээр өнөөдрийн байдлаар 108 долларын үнэтэй нэг тонн коксжсон

нүүрсний маш сайн чанарын нүүрс байгаа. Тун удахгүй арван хэдэн хоногийн дараагаар 85 доллар болохоор шинжтэй байна. Австралид тавьсан 2020 оноос хойш тавьсан нүүрсний импортын одоо хориг тавигдаж эхэлсэн. Маш сайн чанарын нүүрстэй. Энэ одоо импортлогдож эхэлнэ. Хятад руу. Дээрээс нь ОХУ, Индонез төмөр замаараа маш эрчтэй нүүрсээ одоо экспортолж байгаа. Хятадын дотоодын хэрэглээ бол 70-80 сая тоннын л одоо коксжсон нүүрсний хэрэглээтэй байдаг. Тэгэхээр энэ одоо маш их тийм өрсөлдөөн дээр бид нар яаж 50 сая тонн нүүрсийг гаргах вэ гэдэг асуудал гарч ирээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр одоо бид нарын гол орлого бол нүүрсний орлого гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар цаашидаа ямар байр суурьтай байх юм. Ялангуяа энэ дээр нэлээн мэргэжлийн хүний хувьд ТНБД Бүрэн эрхт төлөөлөгч Ганбат дарга хариулья. 2 дугаар микрофон.

Ж.Ганбат: Пүрэвдорж гишүүний асуултад хариулья.

Бид гол экспортоо нэмэгдүүлэх байдлаар ингэж тооцож байгаа. Бид яг өнөөдрийн байдлаар Монгол Улс 25.8 сая тонн нүүрс экспортод гаргачихсан байгаа. Тэгэхээр эхний 6 сарын 13-ны байдлаар 25 сая тонн нүүрс экспорт гаргаж байна. Бид үлдэж байгаа хугацаанд бас энэ хэмжээний нүүрсийг гаргаад 50 орчим сая тонн нүүрс экспортод гаргах бүрэн бололцоотой юм байна гэдэг ийм байдал дээр бол гол орлогынхоо тооцооллыг хийж ингэж оруулж ирсэн байгаа.

Ер нь цаашидаа энэ экспортыг нэмэгдүүлэх тогтворжуулах энэ тал дээр энэ нөгөө шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд боомтын сэргэлтийнхээ хүрээнд өнгөрсөн оноос эхэлж анхаарсны үр дүн энэ оноос өнгөрсөн оны сүүл энэ оноос ингэж гарч байна л даа. Тэгэхээр бид

ямар ч байсан экспортоо нэмэгдүүлснээр төсвийн орлого тогтвортой байлгах ийм бүрэн боломжтой гэдэг ийм байдлаар тооцсон байгаа.

Нөгөө талдаа ковидын дараах эдийн засгийг эрчимжүүлэх бодлогын арга хэмжээний үр дүнд эдийн засгийн өсөлт нэмэгдэж тогтворжих энэ хандах тоо энэ хүрээнд бас төсвийн орлого нэмэгдэх ийм бүрэн боломжтой байгаа гэдэг ийм тооцоолол дээр төсвийн орлогыг үндэслэж тооцсон байгаа.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Саяын таны хэлдэг тоо энэ чинь 4 сарын тоо шүү. Тийм өнөөдөр 6 сарын 13-ны байдлаар нүүрс 26 сая тонн гарчхаад байгаа юм. Хагас жилийн байдлаар 14 хоног дутуу байна 27, 28 сая тонн руу дөхөх болов уу. Сүүлийн өдрүүдэд бас төсвийн тодотгол ярьж байгаатай холбогдуулаад ч тэр юм уу ямар зорилготой юм бүү мэд сүүлийн хэдэн хоногт бараг худалдаа зогслоо экспорт зогсчихсон байна гэж тэгж ярьсан мессежүүд гарсан байна лээ. Энэ ор үндэслэлгүй мэдээлэл. Тодорхой хэмжээнд буурсан уу гэвэл буурсан. Энэ үнэ буурч байгаатай холбогдуулж одоо худалдан авалтуудаа харзсан хойшлуулсан. Мэдээж зах зээл дагаад ийм хөдөлгөөн гарч л таараа. Ийм зүйл. Тэрнээс биш хил хаагдчихсан ч юм уу тийм механик ийм нөлөөлөл байхгүй. Энэ цэвэр зах зээлийн л асуудал. Ер нь яах вэ өмнөх шийдвэрийг нь харах юм бол ингээд нэг жилийн дундуур 6, 7 сар ингээд нөгөө жоохон дүлий болдог, буудаг, ийм хандлагууд байдаг. Эргээд одоо сүүлийн хагастаа өсдөг нэгэнт хэрэгцээ нь байгаа л юм чинь өрсөлдөөн бас байгаа. Гэхдээ Хятадын талаас хэлж байгаагаар бид одоо хил дээр хүргэж чадах цаашаа нэвтрэн өнгөрүүлж чадах хэмжээгээр л худалдаж авъя гэж байгаа юм.

Үүнийг хятадууд ч мэдэхгүй бид ч мэдэхгүй. Энэ дэлхийн зах зээл дээр л тогтдог юм. Мэдээж Хятад гол тоглогч мөн үү, мөн. Ийм байгаа юм. Тийм учраас түрүүн таны хэлдэг тоонууд жоохон хуучирсан тоонууд шүү. 4 сарын байдлаар давсан орлого 340-өөд тэрбум төгрөг. Мөн зардал талдаа хэмнэлт гаргагдсан. Ингээд үндсэн тэнцэл 1.1 их наяд төгрөгийн эерэг гарсан байгаа шүү дээ. Өмнөх жилүүдэд дандаа сөрөг гардаг байсан. Эхний хагас жилд эерэг гарч байгаа энэ тэнцэл сүүлийн хагас жилд болбол энэ нь мэдээж хадгалагдана. Манай бол ер нь жилийн орлогын түвшин ер нь байнга л тэгж явдаг. Байнга л тэгж явдаг. Сүүлийн хагаст нь ер нь манай одоо бүх эдийн засгийн эргэлтүүд ингээд худалдан авалтууд хийгддэг. Бүх одоо бүтээмж одоо эдийн засгийн үр ашгууд нь сүүлийн хагас жилд гарч ирдэг, татвар ч нэмэгддэг, орлого ч нэмэгддэг.

Тийм учраас энэ бол одоо бас биелшгүй тоо биш. Бид одоо боломжит бүх экспортуудаа амжилттай хийгээд төлөвлөж байгаа зүйлүүдийг хугацаанд нь хийгээд одоо төсвийн ерөнхийлөн захирагч нар бүгд одоо хичээж ажиллах юм бол энийг одоо бид биелүүлэх бүрэн боломжтой гэж ингэж харж төлөвлөсөн байгаа. Хүн болгон л асууж байгаа юм. Инфляц инфляц гэж. Мэдээж одоо онол талдаа болбол тийм зүйл байгаа байлгүй яах вэ. Мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж байгаа учраас одоо эрэлт талаасаа одоо инфляцын дарамт нэмэгдэнэ. Мэдээж одоо Засгийн газар Монголбанк одоо энийг хараад сууж байх уу өөрсдийнхөө бүхий л одоо боломж бодлогын хэрэгслээр энийг саармагжуулахын төлөө ажиллана. Гэхдээ нэг ийм зүйл байгаа юм. Орлого нэмэгдсэн хамгийн боломжтой цаг хугацаан дээрээ бид нар одоо энэ цалин, тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгөөр дамжуулж ард иргэдийнхээ одоо бодит орлогыг дэмжиж байгаа. Төрийн албан хаагч нарынхаа үйл ажиллагааг, одоо ажил мэргэжлийг, дэмжиж байгаа

ажлын байраа хадгалахыг нь дэмжиж байгаа. Цаашаага төрийн үйлчилгээг амжилттай тасалдуулахгүй үргэлжлүүлэх тэр боломж нөхцөлийг нь одоо бага ч гэсэн хангаж байгаа юм. Тэгэхгүй бол сүүлийн 3 жил олигтой нэмж чадаагүй энэ төрийн албан хаагч нар маань энэ цалингаараа одоо цаашаа үргэлжлүүлж төрийн албыг одоо хашина гэдэг маш хүнд болж ирж байгаа юм.

Бид нар хагас жил хүлээхэд мэдэхгүй. Тэр үед одоо бид нар хэдэн төрийн албан хаагчаа Солонгос руу алдахыг одоо өнөөдөр хэлж мэдэхгүй. Хэрвээ инфляцынхаа зорилтот түвшинд 6, 8 хувьд очтол ингээд бүтэн жил хүлээх юм бол тэр үед одоо төрийн үйлчилгээ тасалдах хэмжээнд хүртэл эрсдэл байгаа. Тийм учраас өнөөдөр бид нар цаг алдалгүй.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Тэгэх дээр татварын орлого эхний 4 сарын байдлаар бол 36 хувийн өсөлттэй гарч байгаа. Өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад. Тэгэхээр энэ татвар татварын орлого бол инфляцын татварын орлого байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо 3 мянган төгрөг байсан ургамлын тос 9 мянга болчихоор тэрний тэнд ноогдож байгаа НӨАТ борлуулалтын татвар борлуулалтын үе шат болгонд авч байгаа.

Дээрээс нь татварын бусад татварын орлого бас энэ дээр орлогын татвар бас нэмэгдэж байгаа. Тэгээд энэ инфляцын татвар чинь өөрөөр хэлбэл одоо энэ ард иргэдийн барааны үнэ өсөхөд шууд нөлөөлж байна.

Дээрээс нь гадаадаас гадаадын инфляцыг тэр чигээр нь инфляцтай барааг тэр чигээр нь оруулж ирээд тэндээс дахиад татвар авахаар энэ татварын чинь орлого нэмэгдээд байна.

Тэгэхээр энэ дээр бас голлон бидний хийх ёстой чухал ажил бол энэ ялангуяа одоо жишээ нь Замын-Үүдийн

боомт. Бид нар гол бараа бүтээгдэхүүнээ Замын-Үүдийн боомтоор авдаг. Замын-Үүдийн боомт урьд нь 3 сая, 4 сая орчим төгрөгөөр Эрээн Улаанбаатарын хооронд тээвэр хийдэг байсан одоо өнөөдрийн байдлаар 20 гаруй сая төгрөг байж байна. Тэгээд энэ ложистикийн энэ хямрал чинь, ложистикийн энэ авлигал хээл хахууль энэ бүх зүйл чинь өнөөдөр ингээд бараа бүтээгдэхүүний үнийг замбараагүй өсгөөд тэрнээс нэг орлого нь нэмэгдэж харагдаад байгаа юм шиг байгаад байгаа шүү. Тэрэн дээр ялангуяа одоо энэ тал дээр бас нэлээн сайн ажиллаарай гэж бас та бүхэнд хэлмээр байна.

Дараагийн асуулт.

2023 оны энэ жилийн төсвөөр нийт цалин 1.8 их наяд. Нийт цалин 1,8 их наядаар батлагдсан. 2023 оны төсөвт нийт цалин. Тэгээд өнөөдөр одоо ингээд бараг 1 их наяд төгрөгөөр энэ жилийн 2023 оны нийт цалин хэд вэ? Нийт цалингийн хэмжээ цалингийн зардал хэд вэ?

Тэгээд ер нь одоо 4.2-оор нэмэгдлээ гэхэд одоо 1 их наядаар нэмэгдэхээр одоо ер нь дунджаар 20 хувийн нэмэгдэл гарч байгаа юу? 25 тэгээд хамгийн гол нь одоо ингээд цалин нэмэгдэж болдог төрийн албан хаагчдын цалин нэмэгдээд байдаг. Гэтэл энд ямар хүндрэл бий болох вэ гэхээр нэлээн доголдууд гарч ирнэ ээ. Гол доголдууд юун дээр гарч ирэх вэ гэхээр энэ хувийн хэвшлийн байгууллагуудын цалингаа нэмэх, үйл ажиллагаа явуулах тэр асуудал дээр нэлээн дол доголдол гарч ирнэ. Тэгэхээр хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүд яаж дэмжих юм. Гол одоо асуудал энэ хувийн хэвшил дээр байгаа үйл ажиллагаа явуулахад нь тулгарч байгаа тэр хүнд суртлыг яаж арилгах юм. Жишээ нь одоо тэр нэг төмөр замын нэг нөхрийн юунаас 7.3 тэрбум гарч байна шүү дээ. Тэгэхээр нэг дундаж албан тушаалтан. Гэтэл энэ Монгол даяараа бүх салбарт ийм одоо авлигал

хээл хахууль бий болчихсон энэ үед одоо яаж энэ хувийн хэвшилүүдийнхээ үйл ажиллагааг сайжруулах юм. Энэ дээр л одоо гол асуудал байгаа. Энэ чинь сайжирч байж бид нар хувийн хэвшлийн үйл ажиллагаа сайжирч байж л энэ бараа бүтээгдэхүүний үнэ буурна.

Монгол Улсын төсвийн орлого нэмэгдэнэ, ажлын байр хадгалагдана. Ийм л зүйл хийх хийх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ энэ тал дээр ямар ажил байгаа юм. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя.

Түрүүний тэр инфляцтай холбоотой одоо нэмж хэлье. Инфляцын татвар бараг 100 хувь энэ дээр орлогын нэмэгдэл маань инфляцын татвар гээд та хэлчих шиг болох юм 100 хувь ч арай ч тийм биш шүү. Хэрв та одоо Дэд хороон дарга хүн энэ хэдэн тоонуудыг уншиж байгаа болов уу гэж бодож байна. Биет хэмжээгээр нэмэгдсэнийг та жишээ нь юу гэж хэлэх вэ? Би нөгөө мэтгэлцэж байгаа учраас ингэж ярьж байна шүү. Ноднин өдийд 10 сая тонн хүрэхгүй л бид нар экспорт хийчихсэн байсан. Өнөөдөр ингээд 27, 28 сая тонныг гаргачихлаа. Биет хэмжээгээр шүү. Энэ бол инфляцад ямар ч хамаагүй. Харин Засгийн газар энэ одоо гадаад худалдаа ялангуяа нүүрс дагасан энэ хилийн худалдааг бид нар либералчилж энийг илүү их ил тод болгосны үр дүнд ийм зүйлүүд гарсан. Ийм нэмэгдлүүд гарсан.

Мэдээж одоо татварын орлого нэмэгдэхэд инфляцын нөлөө байгаа юу байгаа. Энэ инфляцынхаа хэмжээнээс нэг их давахгүй. Нэг 10-аас 15 хувь дээр л байгаа 100 хувь нэмэгдлээ гэхэд. Харин ер нь 80, 90 хувь нь одоо сүүлийн нэг жил гаран хугацаанд Засгийн газрын одоо энэ экспортоо нэмэгдүүлэх, богино хугацааны төлбөрийн тэнцлийн шокноос гарахын төлөө авч хэрэгжүүлсэн шат дараатай олон арга хэмжээний үр дүнд бий болж байгаа ийм зүйл. Эдийн засгийн

арга хэмжээнүүд ч авлаа, захиргааны шинжтэй арга хэмжээнүүд ч авлаа.

Хууль, цагдаа, шүүхийн байгууллагууд бүх шатанд одоо төрийн байгууллагууд одоо энэний төлөө ажилласны үр дүн гэж хэлмээр байна. Цалин мэдээж одоо бусад хувийн секторууд руу бол нөлөөлөх нь нөлөөлнө. Тэгэхдээ нэг ийм одоо харьцаа байдаг юм шүү Пүрэвдорж дарга аа.

Төрийн албан хаагч 217 мянга. Нийт цалингийн систем авч байгаа одоо иргэдийн тоо сая 200 сая. Нийт Монгол Улсын цалингийн фонд ер нь нэг жил бүр 1-ээс 2 их наядаар нэмэгдээд явдаг юм. Өнгөрсөн онтой харьцуулах юм бол энэ 4, 1-ийн харьцаатай байгаа. Өөрөөр хэлбэл нийт Монгол Улсын цалингийн сангийн 1/4 нь төрийн албан хаагч нарынх, 3/4-ний хувийн секторынх гэсэн үг. Гэхдээ дундаж хэмж нь бол хувийн секторынх одоо бага зэрэг өндөр явдаг. Төрийн алба хувийн секторынх нь ч нэмэгдээд байгаа нь эргээд төрийн албан хаагч нар төрийн албанаасаа одоо зугтах, дайжих ингэж нөлөөлдөг. Төрийн албаны цалин нэмэгдэхэд одоо хувийн секторуудыг зайлшгүй нэмэгдүүлэх энэ байдлаар ч бас харилцан нөлөөлөөд ингээд явдаг.

Энэ удаа төрийн албан хаагч нарын цалин бол хувийн алба одоо сектороосоо хоцорч нэмэгдэж байгаа. Тэгэхээр бол тийм чирэх эрсдэл нь харьцангуй бага гэж бид харж байгаа. Тийм учраас одоо энэ удаагийн нэмэгдэл нь одоо яг цагаа олсон төрийн албан хаагч нар маань одоо төрийн албанаасаа дайжих гарч явах ингэснээр төрийн албаны одоо Монгол төрийн үйлчилгээ Засгийн газрын үйл ажиллагаа доголдох ийм эрсдэлээс ч одоо бид хамгаалж ийм арга хэмжээ авч байгаа гэж ойлгож болно.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг үг хэлэх гишүүн байна уу? Би нэг хэдэн үг хэлчихье.

Тэгэхээр юуны өмнө бас энэ хүүхдийн мөнгийг 100 хувь олгож байгаа. Дээрээс нь цалин, тэтгэвэр нэмж байгаа энэ одоо өнөөдрийн тодотголыг 100 хувь дэмжиж байгаагаа илэрхийлье. Энэ бас Засгийн газрын зарим нэгэн одоо энэ хулгай луйвартай тэмцээний үр дүнд бас тодорхой хэмжээний төсвийн орлого нэмэгдсэн гэдгийг бас тодруулан хэлье гэж бодож байна. Мөн түүнчлэн энэ хүүхдийн мөнгө 100 хувь олгосон тэр цалин тэтгэвэр нэмсэн асуудал бол өөрөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэнтэй шууд холбоотой.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын 76 гишүүнтэй байснаа 126 болж гишүүдийн тоог нэмэх мөн түүнчлэн жагсаалтыг оруулж ирж тэрний ард бас тодорхой хэмжээний нөхдүүд орж ирэх. Энэ боломжийг өөртөө гишүүд өөрсдөө авч байгаагийнхаа үр дүнд ард түмэнд бас тодорхой хэмжээний энэ улсын төсвийн орлого нэмэгдсэний үр дүнд бас энэ цалин тэтгэврийг нэмж байгаа. Хүүхдийн мөнгийг 100 хувь болгож байгаа гэдгийг. Тэгээд дээрээс нь 5 сарын 5-нд анхны хэлэлцүүлэг явагдахад энэ гишүүдийн тоо жоохон 150-иасаа хассан болоод тэгээд бүх юмыг батална. Энэ хоорондоо та бүхэн тойрогтоо ажиллаж байгаа Их Хурлын гишүүддээ цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгөө 100 хувь олго гэж шаардсаны үр дүн шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Хоёрдугаарт нь энэ төсвийн тодотголттой холбоотойгоор зах зээл рүү эдийн засаг руу бас их хэмжээний бэлэн мөнгө орсноор дараах бас үр дүнгүүд асуудлууд гарч магадгүй ээ.

Тэгээд энэ дээр бас манай Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам одоо анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Нэгдүгээрт бол энэ төсвийн тодотгол хийгдсэнээр үнийн өсөлт улам нэмэгдэх ийм нөхцөлийг бий болгоно.

Хоёрдугаарт нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдоно. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнээр тэдний одоо хөрөнгө оруулалт нэмэгдэх ийм нөхцөл байдал руу орж байгаа.

Гуравдугаарт нь төсвийн алдагдал нэмэгдэж байна.

Дөрөвдүгээрт нь гадаад өрийн хэмжээ нэмэгдэнэ. Яагаад гэвэл оны эцсээр хэрвээ одоо нүүрсний экспорт муудах юм бол бид нарт эрсдэл байгаа. Бид нар энийг одоо гадаад өрөөр хаахаас өөр аргагүй нөхцөл байдал руу орно. Үнийн өсөлт нэмэгдсэнтэй холбоотой үнийн өсөлт бий болсонтой холбоотойгоор инфляцын татварын хэмжээ орлого нь илүү нэмэгдэнэ. Энэ нь юуг илэрхийлж байна вэ гэвэл хүмүүсийн карманаас суйлах нь ихэснэ л гэсэн үг.

Зургаадугаарт нь валютын хани чангарна, түүний үр дүнд төгрөгийн хани суларна.

Долоодугаарт нь хэт их инфляцтай, дээрээс нь хани уналттай энэ газар гадаадын хөрөнгө оруулалт буурах магадлал бий болно.

Наймдугаарт нь, оны эцсээр цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгөө 100 хувь өгч чадахгүй нөхцөл байдал руу орж магадгүй шүү.

Тэгэхээр энэ бүх зүйл дээр бас тодорхой анхаарлаа хандуулж Засгийн газар ажиллаарай гэж хэлэх байна.

Гишүүд үг хэлж дууслаа.

Төсвийн тодотголын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төсвийн тодотголын төсөлтэй холбогдуулан санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

71.4 хувиар төслийг дэмжлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Дүгнэлтийг Төсвийн байнгын байнгын хорооны хурал дээр би танилцуулна. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа.

*Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ
ШИНЖЭЭЧ*

*АЛБАНЫ
П.МЯДАГМАА*